

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**



**ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023 он

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 оны 11 дүгээр сарын 24

Сүмбэр сум

НЭГ. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Монгол улсын Үндсэн хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, ХЗДХЯам, УБЕГ-аас гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ “Иргэнд суурилсан төрийн бүртгэлийн үнэн ой санамжийг бий болгох, төр, иргэнийг холбосон бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрийн бүртгэлийн үйлчилгээгээр иргэний эрхийг хангах” эрхэм зорилгыг ханган, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байна.

Тус хэлтэс нь хэлтсийн дарга 1, тасгийн дарга бөгөөд улсын улсын ахлах бүртгэгч 2, хяналтын улсын байцаагч 1, улсын бүртгэгч 6, ахлах нягтлан бодогч 1 нярав, бичиг хэргийн ажилтан 1, мэдээлэл технологийн ажилтан 1, архивч 1, гэрээт ажилтан 6 (гэрээт 1, үйлчлэгч 1, харуул 4) тус тус ажиллахаас жилийн эцсийн байдлаар 17 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй төрийн бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн жигд явуулж байна. Жилийн эцсийн байдлаар сул орон тоо байхгүй байна.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн сул орон тоонд Дундговь аймгаас Р.Мөнхбат, Ж.Аззаяа, Баянтал сумын улсын бүртгэгчийн сул орон тоонд Дундговь аймгаас Б.Цэрэнням нарыг хуулийн дагуу тус тус шилжүүлэн ажиллуулах ажлыг зохион байгуулав. Р.Мөнхбат аймгийн Шүүхийн Тамгын газарт 4-р сард шилжин орсон болно.

Хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах ажлын хүрээнд хэлтсийн “Угтах үйлчилгээний ажилтан”-аар Э.Мөнхнаранг 2019 онд томилон ажиллуулсан бөгөөд 2023 онд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болно.

Албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг баталсан бөгөөд жилийн эцсийн байдлаар нийт албан хаагчид ээлжийн амралтаа бүрэн авч дуусаад байна.

Хэлтсийн “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г хугацаанд нь боловсруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, аймгийн Засаг даргаар тус тус батлуулан, хэрэгжилтийг нь хангах ажлыг зохион байгуулж байна. Мөн ажилтнуудын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г баталж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж байна.



Мөн албан хаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлахдаа “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг”-аа эргэн санаж, нийт албан хаагчдад уншиж, танилцуулсан болно.



Тайлангийн хугацаанд хэлтсийн нийт албан хаагчдын хурлыг 18 удаа зохион байгуулсан бөгөөд хурлаар өнгөрсөн хугацаанд хийсэн ажлаа дүгнэж, цаашид хийх ажлаа зөвлөлдөж, тодорхой шийдвэрүүд гаргаж хэрэгжүүлдэг болно. Мөн хууль, тогтоомж, дүрэм журам, судалж танилцах, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, ажилтнуудын сахилга хариуцлага ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх асуудлуудаар заавар, чиглэл өгч, хурлын тэмдэглэл хөтөлдөг болно. Энэ хугацаанд сахилгын зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.

Улсын бүртгэлийн хэлтэс нь аймгийн Цагдаагийн хэлтсийн хуучин байр болох 1971 онд ашиглалтад орсон 100,5 м/кв талбайтай, өргөтгөл нь 2008 онд ашиглалтад орсон нийт 506,94 м/кв талбайтай байранд 49.0 сая төгрөгөөр урсгал засвар хийж, байрны нээлтээ 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр ёслол төгөлдөр зохион байгуулж, албан хаагчдын ажиллах тав, тухтай орчин нөхцөлийг нэмэгдүүлээд байна.

Нээлтийн арга хэмжээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвлөл бүрэн бүрэлдэхүүнээр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ш.Билэггүмбэрэл, Аймгийн Засаг даргын орлогч Б.Наранбаатар, аймгийн төрийн болон аж ахуйн нэгжийн дарга, удирдлагууд, улсын бүртгэлийн байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд, өмнө ажиллаж байсан албан хаагчид оролцлоо.

Нээлтийн арга хэмжээний үеэр Ардын хувьсгалын 100 жилийн ойн медалиар тус хэлтсийн ахмад настан Ж.Адилбиш, Ц.Урангуа, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Говсүмбэрийн төлөө” медалиар Ц.Урангуа, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр улсын ахлах бүртгэгч Э.Ууганбат, Улсын бүртгэлийн ерөнхий газрын “Жуух бичиг”-ээр Ч.Нарангэрэл, В.Гэрэлчимэг, Ц.Дүгэрсүрэн, Э.Дулмаа, Х.Мягмаржаргал нарыг тус тус шагнаж урамшуулав.



Жилийн эцсийн байдлаар Захиргааны хэргийн шүүхэд холбогдолтой Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн “Орон сууцны хувьчлал”-ын маргаантай 1, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн бүртгэл хүчингүй болгохтой холбоотой 1 хэрэгт тус тус хариуцагчаар оролцож байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн маргаанд ялалт байгуулсан бөгөөд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн маргаан шүүхийн шатанд явагдаж байна. Хэрэг маргааны судалгааг холбогдох газарт хүргүүлсэн.

Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгууль 2023 оны 06-р сарын 18-ны өдөр зохион байгуулагдахаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаартай “Орон нутгийн хурлын нөхөн сонгуулийг товлон зарлах тухай” тогтоол батлагдсан бөгөөд тогтоолын эх хувийг ерөнхий газарт хүргүүлсэн болно. Мөн хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу ажиллав. Нөхөн сонгуулиар ажиллах 3 хэсэгт Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах 4 ажилтныг Хэлтсийн даргын 2023 оны А/17 дугаартай “Итгэмжлэгдсэн ажилтан томилох тухай” тушаалаар томилсон. Улсын бүртгэлийн ерөнхий газраас Сонгуулийн тоног төхөөрөмжийг 2023 оны 6-р сарын 06-ны авах ажлыг хууль хяналтын байгууллагын хамт зохион байгуулав. Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын /нөхөн, дахин/ сонгууль 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Сүмбэр сумын 6-1-3, Шивээговь сумын 6-3-1, 6-3-2 дугаар хэсэгт тус тус зохион байгуулагдаж, тайлан мэдээг дээд байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн бөгөөд Сонгуулийн үйл ажиллагаанд ямар нэгэн зөрчил гараагүй болно.

ХОЁР. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр:

а) Иргэний улсын бүртгэлийн талаар:

Д/д	Бүртгэлийн төрөл	(10-р сарын 25-ны өдөр буюу жилийн эцсийн байдлаар)	
		2022 он	2023 он
1.	Төрсний бүртгэл	142	290
2.	Гэрлэлт	23	52
3.	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл	7	18
4.	Гэрлэлт сэргээлт		
5.	Үрчлэлт	3	4
6.	Эцэг тогтоолт	2	7
7.	Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчлөлт	6	17
8.	Регистрийн дугаар өөрлөлт		
9.	Нас барсны бүртгэл	38	68
10.	Аймаг, хотоос шилжин ирсэн	135	418
11.	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	171	398
12.	Иргэний шинэчилсэн бүртгэл	100	254
13.	25,45 насны сунгалт	185	396
14.	Иргэний үнэмлэх дахин олголт	40	170
15.	Лавлагаа	1111	4444
16.	Үндэсний энгийн гадаад паспорт	119	2108
17.	Үйлчилгээний хураамж	19,383,000	46880300
18.	Тэмдэгтийн хураамж	4,098,000	2306100
	Нийт бүртгэлийн тоо	2082	8644

Иргэний бүртгэлийн дугаарыг 2023 онд хэрэглээнд нэвтрүүлж, шинэчилсэн загвар бүхий бэлдцэд бичилт хийж хэвлэж байгаа бөгөөд 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 820 иргэнд иргэний бүртгэлийн дугаартай цахим иргэний үнэмлэх олгох ажлыг зохион байгуулав.

б) Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар

Д/д	Бүртгэлийн төрөл	(10-р сарын 25-ны өдөр буюу жилийн эцсийн байдлаар)	
		2022 онд	2023 он
	Нийт бүртгэлийн тоо	3034	3017
1.	Төрөөс хувьчилсан газар өмчлөх эрхийн бүртгэл	426	146
2.	Газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл	277	156
3.	Газраас бусад үл хөдлөх хөрөнгийн анхны бүртгэл	75	53
4.	Худалдах худалдан авах гэрээ	401	414
5.	Бэлэглэх гэрээ	59	72
6.	Арилжих гэрээ		18

7.	Өв залгамжлал	53	36
8.	Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх	1	1
9.	Хамтран өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл	31	31
10.	Барьцаат зээлийн гэрээ	682	892
11.	Барьцааны гэрээ дуусгавар болсон	793	768
12.	Түрээсийн гэрээ	2	2
13.	Бүртгэлд өөрчлөлт орсон	57	74
14.	Урьдчилсан тэмдэглэл	20	49
15.	Лавлагаа хуулбар	155	303
16.	Хувийн хэрэг хаасан	2	2
17.	Үйлчилгээний хөлс	33,448,397	28,217,425
18.	Тэмдэгтийн хураамж	530,575	226,594
19.	Татварын орлого (2 хувь)	101,702,572	150,714,965

Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэгч нь хуульд эрх зүйч мэргэжилтэй байхаар зохицуулагдсан байх тул өнөөдрийн байдлаар Баянтал, Шивээговь сумдад ажиллаж байгаа улсын бүртгэгч нар дээрх шаардлагыг хангаагүй байна. Харин иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх үүднээс сумдад газрын анхны бүртгэлийн мэдүүлгийг хүлээн авч, бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 16 мэдүүлгийг сумдаас хүлээн авч бүртгэж, гэрчилгээг иргэдэд гардуулаад байна. Мөн сумдаас ирж бүртгэл хийлгэж байгаа тохиолдолд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай бүртгэхэд анхаарч ажиллаж байна.

в) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаар

/д	Бүртгэлийн төрөл	(10-р сарын 25-ны өдөр буюу жилийн эцсийн байдлаар)	
		2022 он	2023 он
1.	ХХК	34	28
2.	ТББ	4	1
3.	Хоршоо	8	1
4.	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага		3
5.	Шилжиж ирсэн	4	2
6.	Хуулийн этгээдийн салбар	5	4
7.	Хуулийн этгээдийн өөрчлөлт	107	66
8.	Дахин гэрчилгээ шинээр авсан	14	29
9.	Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийсэн	117	72
10.	Хураасан тамга тэмдэг	20	6
11.	Тамга тэмдгийн хяналтын хуудас олголт	73	48
12.	Лавлагаа	3	2
13.	Хориг тавьсан	1	
14.	НИЙТ	390	262
15.	Тэмдэгтийн хураамжийн дүн (төгрөг)	6,531,000	6,068,000

ГУРАВ. Архив, албан бичиг хөтлөлтийн чиглэлээр:

Жилийн эцсийн байдлаар иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн нийт 4659 улсын бүртгэлийн эх нотлох баримт болон цахим бүртгэлд холбогдох баяжилтыг хийгээд байна. Үүнд:

- ❖ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2695 хувийн хэрэгт,
- ❖ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 98 хувийн хэрэгт,
- ❖ Иргэний улсын бүртгэлийн 1866 хувийн хэрэгт тус тус баяжилтыг хийсэн болно.

Аймаг, нийслэл рүү шилжин явсан 93 иргэний хувийн хэргийг зохих журмын дагуу холбогдох аймаг газруудад нь шилжүүлсэн.

Мөн байгууллагын архивд байнга хадгалах 86, түр хадгалах 434, 70 жил хадгалах 39 нийт 559 хадгаламжийн нэгж тус тус хадгалагдаж байна.

Тайлангийн хугацаанд Шүүх, Прокурор, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон бусад төрийн байгууллагын хүсэлтээр нийт 1076 лавлагаа мэдээллийг цаг хугацаанд нь хүргүүлсэн болно. Үүнд:

-Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 823 иргэний лавлагаа,

-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр эрх түдгэлзүүлсэн 52, эрх сэргээсэн 39, лавлагаа 126, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэсэн 18 нийт 235,

-Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 18 тус тус болно.

Мөн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт улирал бүр ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн судалгааг гарган өгч хамтран ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас улсын бүртгэлийн үйлчилгээний КИОСК машин, мөн “Хаан банк”-наас КИОСК машиныг тус тус үйлчилгээний танхимд байршуулан ажиллав. Тус 2 КИОСК-оор дамжуулан иргэд тоон гарын үсгээ түргэн шуурхай авах боломж бүрдээд байгаа юм.

e-Mongolia цахим мэдээллийн сангаас нийт 22 төрийн байгууллагын 155 нэр төрлийн лавлагаа (Улсын бүртгэлийн байгууллагын 23 лавлагаа) мэдээллийг иргэн өөрийн нэр дээр бүртгэлтэй утасны дугаар болон тоон гарын үсгээрээ дамжуулан цаг хугацаа, орон зайнаас үл хамааран үнэ төлбөргүй авах боломжтой болсон бөгөөд иргэдэд өдөр бүр цахимаар хэрхэн лавлагаа авахыг сурталчлан ажиллав.

Хэлтэс өөрийн албан байртай болсноор архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл сайжирсан бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газраас зориулалтын 9 шүүгээ, тавиурын асуудлыг бүрэн шийдвэрлэж өгсөн.

Архивын өрөөнд 3, архивын үүдэнд 2, архивын өрөөний гадна талд 3 камерыг тус тус байршуулж, 24 цагийн харуул хамгаалтаар хянаж байна.



Архивын аюулгүй байдлыг хангах үүднээс хяналтын камер, агаарын даралт, чийгшил хэмжих зориулалтын багаж, цэнэг бүхий галын хор, хүрз, тармуур, элс зэргийг байрлуулав.

УБЕГ-ын даргын 2014 оны 814 дугаар тушаалын дагуу архивын ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн зааврын дагуу нийт 44 удаа чийгтэй цэвэрлэгээ хийж, архивын чийг, дулааныг өдөр бүр хэмжиж тэмдэглэл хөтлөн, хадгалагдаж байгаа хувийн хэргийн аюулгүй байдлыг хангаж байна.

Хэлтсийн байранд албан хаагчдын санаачилгаар “Галын сараа”-г мэргэжлийн байгууллагаар хийлгэж, байршуулах ажлыг зохион байгуулав.



ДӨРӨВ. Албан бичиг хөтлөлтийн чиглэлээр

Улсын бүртгэлийн ерөнхий газраас баталсан хуваарийн дагуу сар, улирлын улсын бүртгэлийн үйлчилгээний тоон мэдээ, тайлан, үнэт цаасны зарцуулалтын тайлан тооцоог хугацаанд нь үнэн зөв гарган хүргүүлж, баталгаажуулж хэвшсэн.

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар нийт 26 өргөдлийг зохих журмын дагуу бүртгэсэн. Үүний 8 өргөдөл нь албан хаагчдаас, 18 өргөдөл нь иргэдээс ирсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар, улирал бүр холбогдох газарт хүргүүлж, ирсэн өргөдөл, гомдлыг EDOC системд тухай бүр бүртгэж, хяналт тавьж ажиллав. 26 өргөдлийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бодлого, төлөвлөлт, дүн шинжилгээний газраас “Улсын бүртгэлийн байгууллагад 2023 оны 1-р улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт-шинжилгээ хийсэн бөгөөд үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг бүртгэл хяналтад авч, биелэлтийг 05 дугаар сарын 10-нд хугацаанд нь гаргаж хүргүүлэв.

Тайлангийн хугацаанд /2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар/ Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим [/govisumber@burtgel.gov.mn](mailto:govisumber@burtgel.gov.mn), 21aimag@burtgel.gov.mn/ хаягаар 156 дотоод албан бичиг, EDOC, ERP системээр 397, бусад байгууллагаас цаасаар 583, нийт 1136 албан бичиг ирснийг бүртгэлд авч, 358 албан бичигт хариу хүргүүлэв. Хугацаа болоогүй 5 бичиг хяналтад байна.

Тус хэлтсээс 497 албан бичгийг явуулж, 8 албан бичгийн хариуг авсан байна.

Хэлтсийн даргын А тушаал 27, Б тушаал 24, нийт 51 тушаалыг зохих журмын дагуу гаргаж албажуулсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А тушаал 9. Үүнд: Индекс батлах тухай-1, Эрхийн улсыг бүртгэл хаах тухай-2, Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр тухай 1, Итгэмжлэгдсэн ажилтны орон тооны дээд хязгаар батлах тухай-1, Тушаалд өөрчлөлт оруулах, маягтын загвар батлах тухай-1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар авах арга хэмжээний тухай-1, Төсвийн шууд захирагч нарт үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, улирлын ажлын үнэлгээгээр урамшуулал олгох тухай-1, Журам батлах тухай-1

Б тушаал 21. Үүнд: Томилгоотой холбоотой 8, Албан тушаалын зэрэг дэв олгох тухай-1, Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай 2, Хүүхэд асрах чөлөө олгох тухай-2, Гэрээт албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоох тухай 2, Хоол, унааны нөхөх төлбөрийг шинэчлэн тогтоох тухай-2, Ээлжийн амралтын хуваарь батлах тухай-1, Аймгуудын Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар батлах тухай-1, Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг шинэчлэн тогтоох тухай-1, Тушаалд өөрчлөлт оруулах тухай-1 тушаал ирүүлснийг тус тус бүртгэж, хэрэгжилтийг хангаж байна.

УБЕГ-аас иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, хяналт, архивын чиглэлээр ирүүлсэн 29 чиглэлийг бүртгэл хяналтад авч, хэрэгжилтийг хангах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллав.

- Дээд газраас ирүүлсэн албан бичиг, чиглэлийн дагуу холбогдох тайлан мэдээ, судалгааг тухай бүр хугацаанд нь гарган хүргүүлэн ажиллаж байна.

-Хэлтсийн даргын 2022 оны А/13 дугаартай “Хэвлэмэл хуудас индексжүүлсэн тухай” тушаалын дагуу хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавьж, бүртгэл хөтөлж байна.

ТАВ. Бүртгэлийн хяналт шалгалтын чиглэлээр

Тайлант хугацаанд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 50 удаа хийсэн. Үүнд:

- ❖ Гүйцэтгэлийн шалгалт-1
- ❖ Гэнэтийн болон төлөвлөгөөт бус-14
- ❖ Өргөдөл, гомдлын мөрөөр-35

Байнгын болон түүвэрчилсэн шалгалтаар нийт 2209 бүртгэлд хяналт шалгалт хийсэн. Нийт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 1101, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 968, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 67, архивын чиглэлээр 73 бүртгэлд хяналт шалгалтыг тус тус хийсэн байна.

Улсын бүртгэгчийн алдаатай 10 зөрчлийг илрүүлж, зөрчил гаргасан улсын бүртгэгчид зөрчлийн тэмдэглэл үйлдсэн болно.

Хяналтын улсын байцаагчийн 35 дүгнэлт гаргаж, бүртгэлийн зөрчлийг арилгасан. Үүнд: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 11, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 24

Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулсан 46 иргэнийг 1030000 төгрөг, 1 аж ахуйн нэгжийг 500000 төгрөг, нийт 1530000 төгрөгөөр журмын дагуу торгосон байна. Зөрчлийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, аймгийн Прокурорын газарт тухай бүр нь хянуулсан.

Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавьж, улсын бүртгэгч нарт мэргэжил арга зүйн заавар зөвлөгөөг хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгчээс өгч, бүртгэлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Гэрчилгээ, үнэт цаасны зарцуулалтад сар бүр тогтмол хяналт тавьж, хүчингүй болсон үнэт цаасыг улсын бүртгэлийн хэлтсийн өмч хамгаалах комиссоор шийдвэрлүүлсэн. Үнэт цаас хүчингүй болгосон улсын бүртгэгч нарт алдаа гаргахгүй ажиллах талаар заавар зөвлөмж өгсөн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас 2023 оны 02-р сарын 06-ны өдрөөс 03-р сарын 01-ны өдрийн хугацаанд цахимаар төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг хийсэн. Тус хяналт шалгалтаар Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 11, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 9 нийт 26 зөрчилд зөрчлийн тэмдэглэл үйлдэж, Хяналтын улсын байцаагчийн 2023 оны 03-р сарын 27-ны 14 дугаартай “Албан шаардлага”-ын дагуу зөрчлийг арилгах талаар арга хэмжээг шуурхай зохион байгуулж, албан шаардлагын хариуг илтгэх хуудсаар хугацаанд хүргүүлсэн. Цаашид улсын бүртгэгч нарт бүртгэлийн алдаа, зөрчил гаргахгүй байх тал дээр байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Нэгдсэн архивын газраас тус хэлтсийн 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд бүртгэсэн хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг цахимжуулах, архивлах, лавлагаа олгох үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 08 дугаар сарын 21-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний хугацаанд хийж гүйцэтгэв. Шалгалтаар илэрсэн зөрчлийг дахин гаргахгүй байх тухай “Албан шаардлага”-ын дагуу зөрчлийг арилгах талаар арга хэмжээг шуурхай зохион байгуулж, албан шаардлагын хариуг илтгэх хуудсаар хугацаанд хүргүүлсэн

ЗУРГАА. Төсөв, санхүүгийн чиглэлээр:

Тайлангийн хугацаанд нийт 377.752.600 төгрөгийн санхүүжилтээс 11-р сарын байдлаар 377.752.600 төгрөгийн санхүүжилт хийгдэж, 333.649.636 төгрөг зарцуулаад байна. Өглөг урсгал засварын зардал болон бичиг хэргийн материалд үүссэн болно.

2022 оны Санхүүгийн Аудитаар өөрчлөлтгүй дүгнэгдсэн. 2023 оны санхүүгийн тайланд “Баталгаат тооцоолол аудит”-аар хийлгэх Аймгийн төрийн аудиттай гурвалсан гэрээ байгуулж, завсрын аудитад 3-р улирлын баримтуудыг хүлээлгэн өгөөд байна.



Хэлтсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгө, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, сар, улирлын санхүүгийн тайлан мэдээг Улсын бүртгэлийн ерөнхий газарт PDF болон файлаар хугацаанд нь хүргүүлсэн мөн холбогдох сайтад байршуулсан бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газарт 11-р сарын 15-ны өдрийн байдлаар нийт 60.000.000 төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй бол 56.147.662 төгрөгийг төвлөрүүлээд 93.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 онд нийт 163 мэдээ оруулахаас 11-р сарын байдлаар шилэн дансанд 143 мэдээ мэдээллийг хугацаанд нь байршуулсан бөгөөд хугацаа хожимдуулсан мэдээлэл байхгүй.

Санхүүгийн тайлан, мэдээг Улсын бүртгэлийн ерөнхий газарт PDF файлаар сар, улирлын мэдээг хугацаанд нь хүргүүлсэн. Хугацаа хоцроогүй болно.

Бичиг хэрэг болон шатахуун худалдан авахдаа холбогдох газруудаас үнийн санал авч, хамгийн бага үнийн дүнтэй газартай гэрээ байгуулан худалдан авалтыг хийж байна. Мөн албан хаагчдын үндсэн цалин болон УБЕГ-н даргын тушаалаар хоолны мөнгө нэмэгдсэн.

Хэлтсийн туслах аж ахуйн 39 толгой малаас албан хэрэгцээнд 12 толгой малыг зарцуулсан байна. Жилийн эцсийн байдлаар мал маллаж буй айлдаа албан хаагчид бүрэн бүрэлдэхүүнтэй очиж гэр нүүлгэх, хороо хашааг нь янзлах, үхэр саах зэргээр өөрсдийн нөөц боломжоороо туслах үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулаад байна.



Тус хэлтэс нь Цагдаагийн хэлтсийн хуучин байр болох 1971 онд ашиглалтад орсон 100,5 м/кв талбайтай, өргөтгөл нь 2008 онд ашиглалтад орсон нийт 506,94 м/кв талбайтай байранд нийт 49.0 сая төгрөгийн засвар хийж, байрны нээлтээ 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр ёслол төгөлдөр зохион байгуулав.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас сургалтын ширээ 8, сандал 23 ширхгийг тус тус шийдвэрлэж өгөв.



Тайлант хугацаанд архивын өрөөнд 3, үйлчилгээний танхимд 2, үүдний хэсэгт 2, гадаа 3 нийт 10 камерыг 6.149.000 төгрөгөөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газрын 4 албан хаагч ирж суурилуулах ажлыг зохион байгуулав.



Иргэдэд төрийн бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газраас үйлчилгээний хөлс төлөх 2 ширхэг “Пос машин”-ны асуудлыг шийдвэрлэж өгсөн. Үр дүнд иргэд үйлчилгээний хөлс тушаахаар банк явахгүйгээр пос машинаар төлбөрөө төлж байгаа юм.



Төрийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газраас нийт 25.0 сая төгрөгийн “Киоск машин”-ны

асуудлыг шийдвэрлэж өгсөн. Үр дүнд иргэд лавлагаа мэдээллийг үнэ төлбөргүйгээр түргэн шуурхай авах боломжтой болсон байна.



Хэлтсийн албан байрны цахилгааны асуудал маш хүндрэлтэй, өөрөөр хэлбэл хүчдэл унадаг, цахилгаан нь дийлдэггүй байсныг Улсын бүртгэлийн ерөнхий газраас нийт 13.8 сая төгрөгийн төсвийн асуудлыг шийдвэрлүүлж, 220вт хүчин чадалтай байсан эрчим хүчний эх үүсвэрийг 320вт болгож нэмэгдүүлэх ажлыг аймгийн Цахилгаан дамжуулах газрын мэргэжлийн багаар хийлгэх ажлыг зохион байгуулав.



Орон нутагт ажилласны нэмэгдлийг төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар бодож орон нутгийн болон улсын төсвөөс сар бүр олгох болсонтой холбогдуулан аймгаас 11-р сарын байдлаар нийт 5.031.929 төгрөгийг хэлтсийн 8 албан хаагчид зохих журмын дагуу олгосон байна.

Хэлтсийн архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөлийг сайжруулах зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газраас зориулалтын 9 ширхэг шүүгээ, тавиурын асуудлыг бүрэн шийдвэрлэж өгсөн.



Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулиар ажилласан итгэмжлэгдсэн ажилтны цалин, урамшуулал болон бусад зардалд нийт 6.586.0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаад байна.

ДОЛОО. Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан талаар:

Аймаг орон нутгийн удирдлагуудтай нягт хамтарч ажилладаг бөгөөд жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргаас иж бүрэн компьютерыг гардаж аваад байна. Мөн байрны асуудлаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас бодитой дэмжлэг үзүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/61 дугаартай “Иргэний баримт бичиг, шилжилт хөдөлгөөний хаягийн бүртгэлд үзлэг хийх” тухай захирамж албажсан. Захирамжийн дагуу ажлын хэсгийг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хуралдуулж, гишүүдэд хийх ажлын төлөвлөгөөг танилцуулж, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцсэн. Энэ ажлын хүрээнд 53 аж ахуйн нэгж байгууллагад албан тоот хүргүүлж, 34 байгууллагаас 1102 албан хаагчдын хаягийн судалгааг ирүүлсэн байна. Үүнээс аймгийн харьяалалгүй 114 иргэдийн нэрсийг гаргаж, аймагт шилжүүлэн ирүүлэх тухай албан тоотыг холбогдох байгууллагуудад буцаан хүргүүлсэн.

Үүний үр дүнд 16-аас дээш насны 65 иргэн, 16-аас доош насны 45 хүүхэд өөр аймаг Нийслэлээс Говьсүмбэр аймагт шилжин ирсэн байна. Мөн багийн Засаг дарга нараас ирүүлсэн түр оршин суух бүртгэлтэй 508 иргэний нэрсийг нэг бүрчлэн шүүж үзэхэд аймгийн харьяалалгүй 440 иргэн бүртгэлтэй байсныг тогтоож, байнгын оршин суугчаар бүртгүүлэх тухай албан тоотыг сумын Тамгын газарт хүргүүлж ажиллав. 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 21 байгууллагын 86 иргэн өөр аймгийн харьяалалтай байна. Өссөн дүнгээр Улаанбаатар хотоос 129 /налайх-2, багануур-6, багахангай-3/ мөн өөр аймгаас 289 нийт 418 иргэн шилжин ирсэн байна.

2023 оны 05 дугаар сарын 15, 16-ны өдөр аймгийн Засаг дарга Шивээговь сумын иргэдтэй уулзалт хийж санал хүсэлт, тулгамдаж буй асуудлуудыг сонсов. Уулзалтад аймгийн Засаг дарга Г.Батсуурь, аймгийн Засаг даргын орлогч Б.Наранбаатар, Шивээговь сумын Засаг дарга П.Ганчимэг, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга А.Дэлгэрзаяа, аймгийн төрийн байгууллагуудын удирдлага, ажилтнууд болон Шивээговь сумын 100 гаруй иргэн оролцож, тус хэлтсээс иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэж ажиллав.



Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт улирал бүр ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн судалгааг гарган өгч хамтран ажиллаж байна.

Аймгаас зохион байгуулсан Төрийн жинхэнэ албаны шалгалтын комиссын бүрэлдэхүүнд тус хэлтсээс иргэний бүртгэлийн ажилтнаар Иргэний бүртгэлийн тасгийн дарга Ш.Уранчимэг, улсын бүртгэгч Б.Болортуяа нар ажиллав. Алдаа зөрчил гараагүй болно.

Жилийн эцсийн байдлаар 414 худалдах худалдан авах гэрээний бүртгэлийг хуулийн дагуу бүртгэх, Татварын байгууллагад бүртгүүлэн 2 хувийн татварын нэхэмжлэл үүсгэх ажлыг зохион байгуулав. Тайлант хугацаанд үл хөдлөх худалдан борлуулсны 150.714.965 төгрөгийг орон нутагт төвлөрүүлсэн байна. Мөн байгууллагын санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь цахимаар хүргүүлж хэвшээд байна.

“Нэг өрх-нэг ажлын байр” арга хэмжээний хүрээнд байгууллагад хувиарлагдсан өрх болох Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2-р баг уулзвар 1-15 тоот хаягт оршин суух Адъяасүрэнгийн Майцэцэгийн гэр болон ажлын байранд 2 удаа биечлэн очиж уулзаж, амьдрал ахуйтай нь очиж танилцах, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулав. Охин Б.Ариунгэрэлийг аймагт хичээллэх сувилахуйн ухааны сургуульд суралцаж болох, өөрсдийн өмчилж байгаа 475 м.кв газрыг хэмжүүлэх талаар холбогдох төрийн байгууллагатай тус тус холбож өгсөн. А.Майцэцэгийн хувьд иргэний бичиг баримтын ямар нэг зөрчилгүй байхгүй болно.



Хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, аймгийн хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой хуулийн байгууллагуудын удирдлагуудын уулзалтыг Шүүх шинжилгээний албатай хамтран 2023 оны 10 дугаар

сарын 20-ны өдөр зохион байгуулав. Уулзалтаар байгууллагууд үйл ажиллагааны танилцуулгыг хийж, цаашид хийх ажлын талаар санал солилцлоо.



Тус хэлтэс гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөс улс орон даяар зарлан мэдээллийн дохиог 3 удаа дамжуулж, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд идэвхтэй хамрагдлаа.




ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн нийгмийн ухааны салбарын “Төрийн удирдлага” хөтөлбөрийн 2 дугаар курсийн оюутнууд танилцах дадлага хийх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газар болон Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаатай 06-р сарын 07-ны өдөр танилцан, төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж туршлага судаллаа.



Байгууллагын нэр хүндийг өндөрт өргөх, сурталчлах ажлын хүрээнд аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо”-ны тэргүүн Д.Цэндмаатай уулзаж, аймгийн хөгжлийн бэрхшээлтэй 11 иргэнд Улсын бүртгэлийн байгууллагын талаар мэдээлэл

хүргэж, 7 иргэнд тоон гарын үсэг олгож, иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн 1 иргэнийг бичиг баримтжуулах ажлыг зохион байгуулан ажиллав.



Хэлтсийн албан хаагчдын дотоод уур амьсгалыг сайжруулах, найрсаг хамт олныг бий болгох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн “XS клуб”-ын тэргүүн Б.Хишигжаргалын удирдлага дор нийт албан хаагчдад зөв хооллолтын талаар мэдээлэл хүргэж, дасгал хөдөлгөөн хийж, эрүүл хооллолтоор өдрийн зоог барих ажлыг зохион байгуулж ажиллав.



Тосгүй, усгүй, давсгүй буюу эрүүл, зөв хооллолтыг хийх гэж байгаа нь



Эрүүл зөв хооллолтын талаар албан хаагчдад мэдээлэл хүргэж байгаа нь



Дасгал хөдөлгөөн хийж байгаа нь



Сунгалтын дасгал хийж, багш мэдээлэл хүргэж байгаа нь

2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр хэлтсийн бүх албан хаагчид Говьсүмбэр аймгийн газрын зургаар зурсан ногоон байгууламжид Байгаль орчин аялал жуулчлалын газрын хяналтын дор 75 ширхэг хайлаас мод тарих ажлыг зохион байгуулав. Байгууллагын гадна талын өнгө үзэмжийг нэмэгдүүлж, цэцгийн үр суулгаж, ногоон байгууламжид байнгын цэнэг усалгааг хийж байна.



Эх дэлхийгээ хайрлан хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг зохион байгуулж байгаа тус хөдөлгөөний хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон 10-р сарын 17-ны өдөр Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газарт намрын тариалалтаа хийж, 20 ширхэг хайлаас модыг тариалах ажлыг зохион байгууллаа.



Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хамт олноороо байгууллагын хариуцсан газар болох аймгийн үдэлтийн хаалганы дэргэдэх 2 талбайн хогийг 4 удаа цэвэрлэж, цэнэг усалгааг Сум дундын ойн ангиас гаргасан усалгааны хуваарийн дагуу 5 удаа хийгээд байна.



Байгууллагын албан хаагчдад хог хаягдлын менежментийн үйл ажиллагааг сурталчилж, зориулалтын 8 ширхэг хогийн савыг нийт 156000 төгрөгөөр худалдан авч байршуулаад байна. Албан хаагчдад хогийг зөв ангилан ялгах, зориулалтын хогийн саванд хаяж байх талаар чиглэл, зөвлөмжийг байнга өгч, хогийг ангилан ялгаж байна.



Байгууллагын гадна талд зориулалтын хогийн савыг “Тохижилт-Сүмбэр” ӨНОААТҮГ-тай хамтран байршуулав. Өнгө үзэмжийг нэмэгдүүлэн хогийн савыг ногоон өнгөөр будах ажлыг зохион байгуулав.

Байгууллагын ойр орчмын 50м газрын хогийг долоо хоног бүрийн Лхагва гарагт 14 хоног тутам цэвэрлэж, мэдээллийг “Хоггүй Сүмбэр” фейсбүүк хаягт тогтмол байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 20 удаа хог цэвэрлэж, 5 тонн хогийг ачуулах ажлыг зохион байгуулав.



Байгууллагын гадна талын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх үүднээс 15м усалгааны шлангыг 120000 төгрөгөөр худалдан авч, ногоон байгууламжид цэцгийн үр суулгах, байнгын усалгаа хийх ажлыг зохион байгуулав.

Хог хаягдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 298 дугаар тогтоолоор батлагдсан "Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Албан хаагчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх зорилгоор хог хаягдлын менежментийн талаар сургалтыг дотооддоо 4 удаа зохион байгуулж, хогийг зөв ангилан ялгах, зориулалтын хогийн саванд хаяж байх талаар чиглэл, зөвлөмжийг тогтмол өгч ажиллав.

НАЙМ. Идэвх санаачилга, шинэлэг ажлын тайлан

Хэлтсийн албан хаагчдын үйлчилгээний стандартын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж байна. Үйлчилгээний ил тод байдлыг хангах зорилгоор хэлтсийн ажлын байр, үйлчилгээний танхим болон 3 суманд мэдээллийн самбар, саналын хайрцаг ажиллуулж, 70541890, 70543056 дугаарын утсаар мэдээлэл, зөвлөгөөг тогтмол өгч

байна. Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 894 иргэн утсаар зөвлөгөө мэдээлэл авсан бөгөөд иргэдээс ямар нэгэн гомдол гаргаагүй байна.

Монгол улсад 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн 16 насанд хүрсэн иргэн бүрд тоон гарын үсгийг олгож эхэлсэн. Уг ажлыг эрчимжүүлэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар, ХААН банктай хамтран “Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аян”-ыг зохион байгуулж ажиллав. Энэ ажлын хүрээнд төмөр замын болон сургууль цэцэрлэгийн байгууллагуудад албан тоот хүргүүлж, 16-аас дээш насны иргэдэд тоон гарын үсгийг олгох, сургалт сурталчилгааны ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллав. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 16-аас дээш насны 11562 иргэнд тоон гарын үсэг олгохоос, нийт 5728 иргэнд тоон гарын үсгийг зохих журмын дагуу олгож, хамрагдалт 49.6%-тай байна.




Цахим гадаад паспортыг 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс иргэдэд олгож эхлэв. Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан нээлтийн үйл ажиллагааг 2023 оны 3 дугаар сарын 14 –ны өдөр зохион байгуулав. Нээлтэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Нэргүйцэцэг болон иргэдийн төлөөллийг оролцуулан орон нутгийн телевизийн бичлэг хийлгэх ажлыг зохион байгуулсан. Энэ оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 2108 иргэнд цахим гадаад паспорт олгох ажлыг зохион байгуулав.



“Улсын бүртгэлийн дуудлагын үйлчилгээ”-ээр буюу хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үйлчилгээний танхимд хүрэлцэн ирэх боломжгүй иргэдийн хүсэлтийн дагуу,

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх” 425 дугаар ангид очиж иргэний үнэмлэх олгосон 25, гэрлэлтээ батлуулсан 4, тоон гарын үсэг олгосон 2 нийт 31 хүмүүжигчид бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулав.



Хэлтсийн цахим сайтад 62, Говьсүмбэр Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк хуудсанд 151 мэдээ, мэдээллийг байршуулж, иргэдэд хүргэсэн бөгөөд фэйсбүүкийн лайк, шэйр, коммент 3975 цахим сайтын хандалт 2226 тус тус байна. Тухайлбал тоон гарын үсэг олгох, цахим гадаад паспорт болон бусад хийж хэрэгжүүлсэн ажлыг иргэдэд сурталчлан ажиллав.

Жилийн эцсийн байдлаар аймгийн “Говьсүмбэр ГС” телевизтэй албан ажлын байрны нээлт болон цахим гадаад, паспортын талаар 2 удаа хамтарч ажиллав.



Монголын Хуульчдын холбооны Говьсүмбэр аймаг дахь салбар, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүрийн 5 дугаар сарын 01-ны өдөр зохион байгуулдаг “ХУУЛЬЧИЙН ПРО БОНО” өдөрлөгт хэлтсээс 6 албан хаагч оролцож, нийт 21 иргэнд тоон гарын үсэг олгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчилж ажиллав.



Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлын хүрээнд хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдахад мэдээлэл зөрүүтэй өрхийн мэдээллийн зөрүүг арилгах зорилгоор Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Авто тээврийн төв нарын хамтарсан баг 2023 оны 01-р сарын 30-нд Сүмбэр суманд, 31-нд Шивээговь суманд “Нээлттэй Говьсүмбэр” өдөрлөгийг зохион байгуулж, иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 176 иргэний мэдээллийг шалгаж, хаягийн зөрчлийг арилгах талаар иргэдэд зөвлөгөө, мэдээллийг өгч ажиллав.



Албан хаагчдын дунд найрсаг уур амьсгалыг бий болгох, хамт олны эв нэгдлийг бататгах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор тайлангийн хугацаанд Өвөрхангай аймаг болон Бүгд найрамдах хятад улсын Эрээн хот руу хамт олны аяллыг тус тус зохион байгуулаад байна.



“Нэг цонхны үйлчилгээ”- ний танхимын үүдэнд “Иргэдэд үйлчлэх танхим” нэртэй хаягийг хийлгэж байршуулав.



Иргэдэд үйлчлэх танхимд гэрлэлтийн гэрчилгээ гардуулж өгөх хүндэтгэлийн буланг шинээр хийж байршууллаа.



Бүртгэлийн байгууллагын түүхт 83 жилийн ойг тохиолдуулан албан хаагчдын дунд спорт (сагсан бөмбөг, гар бөмбөг, теннис, бильярд, дартс), урлагийн (дуу, бүжиг) бага наадмыг тус тус амжилттай зохион байгуулж, мэргэжлийн шүүгчээр шүүлгэж, түрүүлсэн баг тамирчдыг медаль, бэлэг дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.







Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 83 жилийн ойг угтан бүртгэлийн байгууллагын аймаг, нийслэлийн болон ерөнхий газрын нийт ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулагдсан спортын сагсан бөмбөг, гар бөмбөг, шатар, теннис 4 төрөлт тэмцээнд тус хэлтсээс 5 албан хаагч “Зүүн бүс”-ийг төлөөлж амжилттай оролцлоо.



Нийгмийн сайн сайхны төлөө албан хаагчдын санаачилгаар хэлтсийн байрны үүдэнд стандартын дагуу “Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн”-ний явах налуу шатыг хийж гүйцэтгэх ажлыг зохион байгууллаа.



Мөн хэлтсийн байрны хойд талын явган хүний замын хашлага эвдэрсэн байсныг засаж янзлах ажлыг зохион байгуулав.



Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлын хүрээнд 2023 оны 11-р сарын 06, 07, 08-ны өдөр Баянтал, Шивээговь, Сүмбэр сумдад “Танд хүрч үйлчилье” нээлттэй өдөрлөгийг бүрэн бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 48 бүртгэлийг бүртгэж, 125 иргэдэд зөвлөгөө, мэдээллийг өгч ажиллав.





Хэлтсийн албан байрны баруун талын хананд гэрчилгээ өгч байгаа өнгөт зураг болон хойд талд “Улсын бүртгэлийн хэлтэс” гэсэн хаягжуулалтыг тус тус мэргэжлийн зураачаар хийлгэх ажлыг зохион байгуулав.



Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 83 жилийн ойн баярын хүрээнд албан хаагчдад урам зориг өгөх, найрсаг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Иргэдэд үйлчлэх танхим”-д талархлын буланг хамт олны зүгээс санаачлан зохион байгуулж иргэд, үйлчлүүлэгчдээс чин сэтгэлийн урам зориг авч ажиллалаа.



Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор жил бүр зохион байгуулдаг “Монгол Улсын иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагааг 2023 оны 11-р сарын 25-ны өдөр Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулав. Тус арга хэмжээнд 16 нас хүрч иргэний үнэмлэхээ авах өсвөр үеийн залуусаа нийгэмд түүчээлж буй 23 иргэн андгай өргөж, батламж, иргэний үнэмлэх, дурсгалын зүйлс гардуулах ажлыг зохион байгуулав.



ЕС. Сургалт, сурталчилгааны чиглэлээр

Хэлтсийн 2023 оны 19 заалт бүхий сургалтын төлөвлөгөөг батлуулсан, хэрэгжилтийг хангаж ажиллав. Сургалтын төлөвлөгөөний биелэлтийг гаргасан.

Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймаг орон нутгаас зохион байгуулсан онлайн болон танхимын сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулж ажиллав. Үүнд:

Тайлант хугацаанд нийт 39 удаагийн сургалтад давхардсан тоогоор 147 албан хаагч хамрагдав.

Тодруулбал: Мэргэшүүлэх танхимын сургалт 9 удаа 27 албан хаагч, УБЕГ-аас зохион байгуулсан онлайн сургалт 9 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 39 албан хаагч, аймаг, орон нутаг болон танхимын 16 сургалтад 48 албан хаагч тус тус хамрагдсан байна. Тухайлбал:

- Хэлтсийн 2 албан хаагчийг Орхон их сургуулийн “Эрх зүйч” мэргэжлээр суралцах нөхцөлөөр ханган ажиллаж байна.

- Улаанбаатар хотод 02 дугаар сарын 06, 07-ны өдөр зохион байгуулсан “Шилжилт хөдөлгөөний чиглэлээр орон нутагт ажиллах сурагч баш бэлтгэх” сургалтад хэлтсийн 1 албан хаагч, аймгаас 1 албан хаагч тус тус хамрагдав.

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас 03 дугаар сарын 17, 18-ны өдөр зохион байгуулсан “Удирдах ажилтны сургалт”-нд хэлтсийн дарга хамрагдав.

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсан Нягтлан бодогч нарыг чадавхжуулах сургалтад ахлах нягтлан бодогч хамрагдав.

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас орон нутаг дахь “Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын ахлах бүртгэгчийг мэргэжил арга зүйгээр хангах, ажлын байранд дадлагажуулах” ажлын хүрээнд 05 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулсан сургалтад Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч хамрагдав.

Койкагийн төслөөр Бүгд найрамдах Солонгос улсад зохион байгуулагдсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг цахимжуулах ажлын хүрээнд Солонгос улсын Дээд шүүхийн дэргэдэх Эд хөрөнгийн бүртгэлийн газрын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах сургалтад хэлтсийн дарга З.Баяндугар хамрагдаж, сертификат гардаж авлаа.



Аймгийн Онцгой байдлын газраас “Гал түймэр” “Газар хөдлөлт, гамшгаас хамгаалах төлөвлөгөө” сэдвээр тус тус 2 удаа сургалт зохион байгуулав.



Тагнуулын ерөнхий газрын Говьсүмбэр аймаг дахь хэлтсээс “Терроризм, террорист халдлагаас урьдчилан сэргийлэх” сэдвээр зохион байгуулсан сургалтад албан хаагчид бүрэн хамрагдав.

Хэлний бодлогын үндэсний зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн архивын тасагтай хамтран 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавигдах үндсэн шаардлага MNS:6395:2022 стандартыг хэрэгжүүлэх” сургалтад бичиг хэргийн ажилтан, архивч нарыг бүрэн хамруулав.

Аймгийн Боржигин өв музейн мэргэжилтэн М.Уянга 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 12 албан хаагчдад “Угийн бичиг хөтлөх анхан шатны сургалт” –ыг зохион байгуулав. Угийн бичгийн зураглалаа зурж сурсан. Мөн угийн бичиг хөтөлж, жилийн эцэст шалгуулах үүргийг удирдлагаас өгсөн. Тус хэлтсийн 2 албан хаагч угийн бичгээ хөтөлдөг болно.



Монгол бичиг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3”-ийг хариуцсан ажилтнаар архивч Ц.Дүгэрсүрэнг томиллов. Албан хаагчдад Монгол бичгийн анхан шатны 12 удаагийн сургалтыг зохион байгуулж ажиллав. Хэлтсийн гадна хаягийг монгол бичиг кирилл үсгээр хослуулан шинэчилсэн. Иргэний улсын бүртгэлийн гэрчилгээнд мэдээллийг монгол бичгээр бичдэг болсон бөгөөд иргэдэд монгол бичгийг түгээн дэлгэрүүлж ажиллаж байна. “Хүмүүн бичиг” сонины 25 дугаарыг захиалан албан хаагчдад нээлттэй унших боломжийг бүрдүүлэв.

2023 оны 10 сараас эхлэн 7 хоног бүрийн 4 дэх өдөр “Уншлагын цаг” тусгайлан гаргаж, албан хаагчдад сурснаа бататгах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.



Архивын ерөнхий газраас 04 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулсан 80,000 (наян мянга) төгрөгийн төлбөртэй “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, хэрэг бүрдүүлэх, байгууллагын архивд баримт шилжүүлэх ажлын зохион байгуулалт” сэдэвтэй мэргэшүүлэх сургалтад архивч Ц.Дүгэрсүрэнг онлайнаар хамруулав.

Төрийн албаны зөвлөл /ТАЗ/-өөс 7 хоног бүрийн пүрэв гарагийн 10:00 цагаас төрийн албан хаагчдыг чадавхжуулах “7:4:10” сургалтад 4 удаа давхардсан тоогоор 32 албан хаагч тус тус хамрагдав.

Хүний эрхийн Үндэсний Комисс, “Ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэх иргэний нийгмийн эвсэл”-тэй хамтарч НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр “Ажлын байр-Бэлгийн дарамтгүй орчин” аяны хүрээнд ХЭҮК-ын Говьсүмбэр аймаг дахь референт Б.Наранбаатар “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх” сургалтыг тус байгууллагын удирдлага, албан хаагчдад 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулав.



Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах ажлын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын бүртгэгч нарт бүртгэл хөтлөхөд гарч


болзошгүй эрсдэлийг бууруулах мэргэжил арга зүйгээр хангах, тулгарч буй асуудлаар нэгдсэн ойлголт өгөх сургалтыг хэлтсийн албан хаагчид, сумдын улсын бүртгэгч нарт зохион байгууллаа.




Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулиар албан хаагчдад 2023 оны 10-р сарын 19-ны өдөр сургалт зохион байгуулж, тестээр шалгалт авч, тайланг хугацаанд нь ерөнхий газарт хүргүүлэв.



Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд улсын бүртгэгч Б.Болортуяа "Хорт зуршил, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг 12 албан хаагчдад зохион байгуулав.



Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих мөн гэр бүлийн харилцаа холбоог сайжруулах зорилгоор " Гэр бүлийн харилцаа" сэдэвт сургалтыг хэлтсийн 12 албан хаагчдад зохион байгууллаа.



АРАВ: Бусад зохион байгуулсан ажлын чиглэлээр:

Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг албан хаагчдад Хяналтын улсын байцаагчаас 2 удаа сургалт зохион байгуулж, албан хаагчид бүрэн хамрагдав. Мөн хэлтсийн дарга байгууллагын үйлчилгээний стандарт, ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллах талаар бүх албан хаагчдад үүрэг даалгавар өгсөн бөгөөд одоогийн байдлаар ямар нэгэн зөрчил гаргаагүй болно.

Хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах болон цахим мэдээллийн санд байнгын хяналт тавьж байна. Компьютер, тоног төхөөрөмжүүдэд 14 удаа засвар, үйлчилгээ хийсэн. Мөн компьютер болон мэдээллийн санд нэвтрэх нууц кодыг солих зааврыг тухай бүр тогтмол өгдөг болно.

Мөн сүлжээний серверийн өрөөг тусад нь гаргаж, дотоод сүлжээг албан хаагчдад татан суурилуулж, камер болон сүлжээний аюулгүй байдалд байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Тус хэлтэс өөрийн байртай болсонтой холбогдуулан байгууллагын гадна талд 2 гэрэлтүүлэг, хаягжуулалтыг стандартын дагуу хийлгэж байршуулаад байна.

Албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх зорилгоор “Спортын хамтлаг” байгуулж ажиллав. Үүнд:

-Түмэн дасгалыг 7 хоногт 1-2 удаа хийж хэвшээд байна.

-Нийт албан хаагч 7 хоногт 1-2 удаа бүжгийн багшаар хичээл заалгаж, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж, бүжгийн хөдөлгөөнд идэвхтэй суралцаж байна.

-Аймгийн Политехникийн коллежтой долоо хоног бүрийн мягмар гарагт зааланд тоглохоор гэрээ байгуулж ажиллав.



Байгууллагын албан хаагчдыг архи, согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий газар олон хэлтсийн даргын зүгээс байнгын анхааруулга өгдөг бөгөөд албан байгууллага дотор болон бусад хэлбэрээр архидан согтуурах явдал байхгүй болно.

Аймгийн ахмадын хорооны байранд очиж нийт 52 ахмадад тоон гарын үсэг олгож, мөн иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний талаар цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэх ажлыг хамтран зохион байгуулав.



Боржигины түүх, өв соёлыг таниулах мэдлэг олгох зорилгоор тус хэлтсээс 9 албан хаагч Боржигин өв музейг үзсэн байна.



Албан хаагчдын 2023 оны “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны төлөвлөгөө”-г даргаар батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хагас бүтэн жилийн байдлаар биелэлтийг гаргаж, холбогдох газарт хугацаанд нь хүргүүлэв. Тухайлбал:

-Аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран албан хаагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 3-р сард бүрэн хамруулав.

-Эрх зүйч мэргэжлээр суралцаж буй төрийн захиргааны 2 албан хаагчид цалинтай чөлөө олгов.

-Хэлтсийн туслах аж ахуйн хүрээнд албан хаагчдад тус бүр 12 хонь өгөв.

- Байгууллагаас тэтгэвэрт гарсан 3 ахмадад сар шинийн баяр болон ахмадын баярыг тохиолдуулан хуулийн дагуу нийт 960.0 мянган төгрөгийн тэтгэмж олгож, хүндэтгэл үзүүлэв.



-Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагчдыг маск болон ариутгалын хэрэгслээр байнгын хангаж ажиллав.

-Аймгийн Засаг даргаас өгсөн иж бүрэн компьютерыг 1 албан хаагчид гардуулав.

-Хэлтэс өөрийн албан байртай болсноор архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл сайжирсан бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газраас зориулалтын 9 шүүгээ, тавиурын асуудлыг бүрэн шийдвэрлэж өгсөн.

-Улсын бүртгэлийн ерөнхий газраас 1 нөүтбүүк хүлээн авч, Мэдээллийн технологийн ажилтанд хүлээлгэн өгөв.

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Говьсүмбэрийн төлөө” медалиар Хяналтын улсын байцаагч Ш.Энхцэцэг, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр улсын ахлах бүртгэгч Э.Ууганбат, Улсын бүртгэлийн ерөнхий газрын “Жуух бичиг”-ээр Ч.Нарангэрэл, В.Гэрэлчимэг, Ц.Дүгэрсүрэн, Э.Дулмаа, Х.Мягмаржаргал нарыг тус тус шагнаж урамшуулав.

Тулгар төрийн 2232, Их Монгол Улсын 817, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын улсын бүртгэгч Л.Алдар нь Төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн хүндэт" медаль, Монгол Улсын Засгийн газрын шагнал “УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ” тэмдгээр, Иргэний улсын бүртгэгч Б.Цэрэнням, үйлчлэгч Ч.Цэвэлмаа нар Улсын бүртгэлийн ерөнхий газрын “ЖУУХ БИЧИГ”-ээр тус тус шагнагдлаа.



- Албан хаагчдын дунд найрсаг харилцааг бий болгох зорилгоор албан хаагчдын “Төрсөн өдөр”-өөр хамт олны сангаас 300.000 төгрөгийг олгодог бөгөөд жилийн эцсийн байдлаар нийт 15 албан хаагчдад 4,500.000 төгрөгийг олгож, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.



-Хэлтсийн албан байрны засварын ажилд бодитой хувь нэмэр оруулж, идэвх, зүтгэлтэй ажилласан жижүүр Ц.Батбаатарт 100.000 төгрөг, дурсгалын зүйл гардуулав.

-Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан албан хаагчдын гэр бүлийн дунд “Миний мөрөөдлийн баяр” өдөрлөгийг зохион байгуулж, нийт 720000 төгрөгийн бэлгийг гардуулав.



-Хэлтэс яаралтай түргэн тусламжийн эмийн хэрэгсэл болон даралтын аппараттай болж, бүртгэл хөтөлж, зарцуулалтыг хийж байна.

-Хэлтсийн 1 давхрын 00-оос муу усны үнэр үнэртэж байсныг мэргэжлийн байгууллагаар янзлуулж, засварлах ажлыг зохион байгуулав.



-Архивын ажилтан Ц.Дүгэрсүрэнд сард 1 удаа 3 литр сүү, 2 литр тараг өгч хэвшээд байна.

-Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах үүднээс өрөө тасалгаанд цэцэг тарих аяныг өрнүүлж, бүх өрөөнд цэцэг тарьж эхлээд байна.

-Иргэдэд үйлчлэх танхимд 8 ширхэг нэмэх гэрлийг мэргэжлийн хүмүүсээр хийлгэж, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулаад байна.

-Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг I, II улирлыг дүгнэж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвшөөрлөөр төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад урамшуулал олгох ажлыг зохион байгуулав.

-Орон нутагт ажилласны нэмэгдлийг төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувиар бодож орон нутгийн болон улсын төсвөөс сар бүр олгох болсонтой холбогдуулан аймгаас 11-р сарын байдлаар нийт 5.031.929 төгрөгийг хэлтсийн 8 албан хаагчид зохих журмын дагуу олгосон байна.

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 500, 501, 502 дугаар тушаалаар албан хаагчдын цалин, унаа, хоолны нэмэгдлийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд нийт 17 албан хаагчдад 32.0 сая төгрөгийн цалинг тооцож олгов.

Төрийн алба хаасан удааны жилийн нэмэгдлийг 12 албан хаагчдад зохих журмын дагуу олгоод байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны Б/79 дугаар тушаалаар 2 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг шийдвэрлэв.

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН
ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ТАСГИЙН ДАРГА

Э.УУГАНБАТ

ТАЙЛАН ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА

З.БАЯНДУГАР